



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 05 сарын 16 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### **ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

#### **1 дүгээр зүйл.Зээлийн мэдээллийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:**

1/10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг:

"10.3.Энэ хуулийн 10.1, 10.2-т зааснаас өөр зорилгоор зээлийн мэдээллийг ашиглахыг хориглоно."

2/14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг:

"14.3.Олон улсын жишиг, зарчмыг баримтлан Монголбанкнаас баталсан нөхцөл, шаардлагыг үндэслэн энэ хуулийн 14.1.3-т заасан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсииг тогтооно."

#### **2 дугаар зүйл.Зээлийн мэдээллийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:**

"10.2.Зээлийн мэдээллийг зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтооход ашиглана."

#### **3 дугаар зүйл.Зээлийн мэдээллийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн "зургаан" гэснийг "таван" гэж өөрчилсүгэй.**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН